



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2002 оны 01 сарын 16 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

**НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ, ГАЗРЫН
ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДҮРЭМ, БҮТЦИЙГ
ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 28 дугаар зүйлийн 3 дугаар заалт, "Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь хэмжээний тухай" хуулийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалт, Засгийн газрын 2000 оны 185 дугаар тогтоолын 8 дугаар заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хот байгуулалт, газрын харилцааны газрын дүрмийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

Хоёр. Хот байгуулалт, газрын харилцааны газрыг дарга, орлогч дарга 1, Хот байгуулалтын хэлтэс, газрын харилцааны хэлтэс, хот байгуулалт газрын мэдээллийн төв, Орлого санхүүжилтийн хэлтэстэйгээр орон тооны хязгаарыг 46 хүртэл, дүүргүүдэд Хот байгуулалт, газрын харилцааны албатайгаар орон тооны хязгаарыг 44 хүртэл /үйлчилгээний орлогоос цалинждаг болон нормативаар ажиллах орон тоо орохгүй/ байхаар тус тус тогтоосугай.

Гурав. Хот байгуулалт, газрын харилцааны газрын бүтэц, орон тоо болон дүүргүүд дэх албаны орон тоог 2 дугаар хавсралтаар баталсугай.

Дөрөв. Хот байгуулалт, газрын харилцааны газрын дүрэм, бүтэц шинэчлэгдэж байгаатай холбогдон дүүргүүд дэх Хот байгуулалт, газрын харилцааны албанд ажиллаж байсан төрийн үйлчилгээний албан хаагчдыг Монгол улсын Засгийн газрын 1995 оны 94 дүгээр тогтоолд заасан төрийн захиргааны албан хаагчийн ангилал, зэрэглэлд хамааруулж, тогтоосон болзол журмын дагуу шилжүүлэхийг Нийслэлийн Төрийн захиргааны албаны салбар зөвлөл /Ц.Болдсайхан/-д зөвшөөрсүгэй.

Тав. Газрыг хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор тухайн жилийн газрын төлбөрийн орлогоос 10 хүртэл хувийг зарцуулах асуудлыг боловсруулан Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар шийдвэрлүүлж байхыг Хот байгуулалт, газрын харилцааны газар /М.Цэлмэг/-т үүрэг болгосугай.

Зургаа. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2001 оны 22 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

(Handwritten signature)
М.ЭНХБОЛД

02 0039



Нийслэлийн Засаг даргын 2002 оны захирамжийн 1 дүгээр хавсралт

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ХОТ БАЙГУУЛАЛТ, ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл.

1.1 Нийслэлийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлаг Хот байгуулалт, газрын харилцааны газар нь /цаашид газар гэх/ Нийслэлийн нутаг дэвсгэр дээр Монгол Улсын Газрын тухай багц хууль, “Хот байгуулалтын тухай”, “Барилгын тухай”, хуулиуд болон эдгээртэй нийцүүлэн гаргасан бусад тогтоол, журмын дагуу хот байгуулалт, газрын харилцааны үйл ажиллагааг эрхлэх үүрэг бүхий орон нутгийн төрийн захиргааны байгууллага мөн.

1.2 Газар нь Нийслэлийн Засаг дарга, орлогч, Тамгын газрын удирдлаганд үйл ажиллагаагаа явуулж, ажлаа тайлагнана.

1.3 Газрын бүтэц, орон тооны хязгаарыг Нийслэлийн Засаг дарга тогтоож, даргыг томилж, чөлөөлнө.

1.4 Газрын дарга нь эрх хэмжээний асуудлаар тушаал гаргана.

1.5 Газрын дарга нь батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилж, чөлөөлнө.

1.6 Газрын дарга нь Нийслэлийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр орлогч даргаа томилж, чөлөөлнө.

1.7 Газрын дарга нь Улаанбаатар хотын ерөнхий архитектор, газрын харилцааны хэлтсийн дарга нь Нийслэлийн газрын ерөнхий даамал байна.

1.8 Газар нь дүүргүүдэд өөрийн удирдлага, санхүүжилтэнд ажиллах албадыг байгуулж ажиллуулна. Дүүргийн хот байгуулалт, газрын харилцааны албаны даргыг тухайн дүүргийн Засаг даргатай зөвшилцөж Хот байгуулалт, газрын харилцааны газрын дарга томилж, чөлөөлнө.

1.9 Газрын даргын дэргэд байгууллагын зорилт, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэж байх зөвлөлийг ажиллуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг газрын дарга тогтооно.

1.10 Газар нь тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж, банкинд харилцах данстай байна. Газар нь мэдээллийн нэгдсэн сан болон архивтай байна.

1.11 Дүүрэг хариуцсан газар зохион байгуулагч, төлбөрийн байцаагч нар улсын байцаагчийн эрхтэй байж болно.

1.12 Газар нь батлагдсан төсвийг баримтлан санхүүжих бөгөөд "Газрын тухай" хуулийн 7-р зүйлийн 3 дахь хэсэг, "Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь хэмжээний тухай" хууль, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2000 оны 03/18 дугаар тогтоолын 8-р заалтыг үндэслэн газрын төлбөрийн орлогын 10 хүртэл хувийг газрыг хамгаалах, нөхөн сэргээх, бодлогыг хэрэгжүүлэхэд зориулан Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, тухайн жилд Нийслэлд газар эзэмшүүлэх, ашиглуулах, хамгаалах хөтөлбөр болон батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулна.

1.13 Газар нь хот байгуулалт, газрын харилцаанд гарсан зөрчлийг арилгуулах, газар чөлөөлүүлэхэд түр гэрээгээр ажилчид авч ажиллуулж болно.

1.14 Газар нь дэргэдээ газрын харилцааны асуудлыг хэлэлцэж дүгнэлт гаргах үүрэг бүхий Техникийн байнгын зөвлөлтэй байна. Техникийн зөвлөлийн бүрэлдэхүүн болон ажиллах журмыг газрын дарга батална.

1.15 Газар нь барилгын байршилт тогтоож, газар ашиглуулах эрх олгох үндэслэлийг Нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан Хот байгуулалт, газар зохион байгуулалтын мэргэжлийн комиссийн дүгнэлтийн дагуу боловсруулна.

1.16 Архитектур, хот төлөвлөлтийн орон зай, зохиомж, эзэлхүүн төлөвлөлтийн нэгдсэн зөвлөмж гаргах Хотын архитектурын зөвлөлийг ажиллуулж болно.

1.17 Газар нь "Газрын тухай", "Хот байгуулалтын тухай" хууль, тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих, газрын төлбөрийн орлого бүрдүүлэх талаар бусад байгууллагуудтай ажлаа уялдуулан, хамтран ажиллах.

Хоёр. Хот байгуулалт, газрын харилцааны газрын үүрэг

2.1 Газар нь нийслэлийн нутаг дэвсгэрт хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг хангаж, биелэлтэнд нь хяналт тавих ажлыг эрхлэнэ.

2.2 Барилгажилт, инженерийн бэлтгэл ажил, тэг тэнхлэг тавих, инженерийн хангамжийн бодлогын хэрэгжилтийг нэгтгэн зангидаж, инженерийн шугам сүлжээний горимын тооцоо, балансад хяналт тавьж, инженерийн хангамжийг сайжруулах, шинэ техник технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулана.

2.3 Нийслэлийг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө болон Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, зураг төсөл, салбарын хөгжлийн төлөвлөгөө, гадаад дотоодын хөрөнгө оруулалтаар болон буцалтгүй тусламжаар нийслэлд хэрэгжих хөтөлбөр төслүүдэд, оролцох, санал өгөх, техникийн нэгдсэн шийдэл гаргана

2.4 Газар нь эрх бүхий байгууллагын шийдвэрлэснээр нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарь, Улаанбаатар хот, хот орчмын бүс, тосгоны эдэлбэр газрын хилийн цэсийг албажуулах ажлыг зохион байгуулах.

2.5 Тухайн жилд нийслэлд газар эзэмшүүлэх, ашиглуулах, хамгаалах хөтөлбөрийн төслийг боловсруулж, Нийслэлийн Засаг даргаар уламжлуулан Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан, хэрэгжилтийг хангаж ажиллах

2.6 Газар нь хот байгуулалт, газар зохион байгуулалтын бодлогыг хэрэгжүүлэхдээ нийслэлд тухайн жилд газар эзэмшүүлэх, ашиглуулах, хамгаалах хөтөлбөрийг баримтлана.

2.7 Нийслэлд газрын харилцаа, архитектур, хот байгуулалтын нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх үндэслэл болох нийслэлийн бүс нутгийн хөгжлийн төсөл, Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, тэдгээрийн хүрээнд хийгдсэн эрх зүйн баримт бичгүүдийг зохих шаардлагын хэмжээнд бүрдүүлж, нууцын болон архивын материалуудын иж бүрэн судалгаа, бүртгэл хөтөлж ашиглах, тодотгол, шинэчлэл хийх ажлыг зохион байгуулах.

2.8 Нийслэлийн нутаг дэвсгэрт газар эзэмшиж, ашиглаж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн газрыг улсын бүртгэлд хамруулан, газар ашиглалтын зургийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж бүрээр хөтлөх

2.9 Газрын нэгдмэл сангийн үндсэн болон дэлгэрэнгүй ангилал түүний өөрчлөлт, хөдөлгөөний тайланг жил бүр гаргаж, Нийслэлийн Засаг даргад тайлагнах

2.10 Газрын чанарын болон эдийн засгийн үнэлгээг хийх, газар болон хот байгуулалтын мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах

2.11 Нийслэлийн нутаг дэвсгэрт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах тухай Нийслэлийн Засаг даргын шийдвэрийн төслийн үндэслэлийг боловсруулж, газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээг байгуулан, гэрчилгээ олгон, гэрээнд заасны дагуу газрын төлбөрийг хуримтлуулна.

2.12 Нийслэлд газрын тооллого, тоо бүртгэл, газрын кадастрын ажлыг удирдан зохион байгуулж, хэрэгжүүлэх

2.13 Газрын нэгдмэл сангийн ангиллын газруудын газар зохион байгуулалт, газрын менежментийг эрхлэх

2.14 Газрыг үр ашигтай ашиглах, хамгаалах үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

2.15 Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг хийлгэх, нийтийн эзэмшлийн газрын ашиглалтыг сайжруулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах

2.16 Нийслэлийн нутаг дэвсгэр дэх хот суурин газрын батлагдсан ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, мэдээллийн санд тогтмол баяжилт хийж байх.

2.17 Нийслэл хотын барилгажилтыг тухайн орон нутгийн онцлог, үндэсний архитектурын уламжлал, орон зайн харилцаа, зохиомжинд нийцүүлэн тухайлсан эзэлхүүн төлөвлөлтөөр хэрэгжүүлэх, тохижилт, зам талбай чимэглэл, урлагийн бүтээлүүд, архитектурын жижиг хэлбэрүүдийн цогцолбороор гүйцэтгэх ажлыг зохион байгуулах.

2.18 Архитектурын дэвшилтэт төлөвлөлт, техник, технологийг нэвтрүүлэх, орон зай ашиглалтыг сайжруулах зорилгоор төрийн бус мэргэжлийн байгууллагуудтай хамтран уран бүтээлчид, барилгачидтай хамтын ажиллагааг өргөжүүлэх.

2.19 Хот байгуулалтын бодлогыг зах зээлийн эдийн засгийн нийтлэг хандлагад нийцүүлэн газрын харилцааг боловсронгуй болгох, түүний тулд эхний ээлжинд хот суурин, эдэлбэр газарт, хот байгуулалтын эдийн засгийн үнэлгээ боловсруулж хэрэгжүүлэх, эдийн засгийн чөлөөт бүс, амралт жуулчлалын болон үндэсний парк зэрэг төслүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг Монгол Улсын хүн амын нутагшил, хөгжлийн ерөнхий төсөлтэй уялдуулах .

2.20 Архитектур, хот байгуулалтын төслүүдийг Нийслэлийн Засаг даргаар уламжлан Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулах.

2.21 Хот байгуулалтын үйл ажиллагааны төлөвлөлтийн баримт бичгүүдийг дүүрэг, хороо, оршин суугчдад танилцуулах, сурталчлах, харилцан зөвшилцөж тэдний оролцоотойгоор хэрэгжүүлэх бодлого баримтлах

2.22 Иргэд байгууллагын хүсэлтийг хуулинд заасан хугацаанд барагдуулах, хөнгөн шуурхай болгон тухай бүр тайлагнаж байх

2.23 Газрын даргын нийтлэг хэм хэмжээ тогтоосон тушаалыг тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэст ирүүлж хянуулах

2.24 Байгууллагын хэмжээнд сахилга, дэг журам, төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, төсвийн хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллах.

Гурав. Хот байгуулалт, газрын харилцааны газрын эрх

3.1 Газрыг зөвшөөрөлгүйгээр буюу хуурамч аргаар эзэмшсэн ашигласан, хот төлөвлөлтийн норм дүрэм, ерөнхий төлөвлөгөө зөрчсөн, дур мэдэн аливаа төрлийн барилга байгууламж барьсан, газрыг тогтоосон хэмжээнээс хэтрүүлсэн, зориулалтын бусаар эзэмшсэн бол холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.

3.2 Нийслэлийн нутаг дэвсгэр дээр газрын харилцааны маргаан болон хот байгуулалтын зөрчлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх.

3.3 Барилга байгууламжийн чанар байдалд дүгнэлт гаргуулах үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлэх

3.4 Нийслэлийн нутаг дэвсгэр дээрх өмчийн бүх төрөлд хамаарах байгууллага, аж ахуйн нэгж болон иргэдийн эзэмшиж, ашиглаж буй газар, тэдгээрийн барьж байгаа барилга байгууламжид саадгүй нэвтрэн орж "Газрын тухай", "Хот байгуулалтын тухай", "Барилгын тухай" хууль тогтоомж, хотын ерөнхий төлөвлөгөөний биелэлтэнд хяналт тавих, холбогдох бичиг баримтыг шалгах.

3.5 Газар эзэмшигч, ашиглагчдад газар зохион байгуулалт, газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийлгэх талаар шаардах, хэрэгжилтэнд хяналт тавих.

3.6 Хот байгуулалтын төслүүдийг үндэслэн нийслэлийн бүс нутгийн хөгжлийн үе шатны төсөл, хөтөлбөрийг санаачлан боловсруулах, дэмжих холбогдох шийдвэрүүдийг гаргуулах.

3.7 Архитектур, хот байгуулалтын үнэт өвийг судлан илрүүлэх, бүртгэл хяналтад авах, хамгаалах, сэргээн засварлах, үндэсний архитектурын уламжлалыг хөгжүүлэх талаар холбогдох байгууллагуудад санал оруулах, шийдвэр гаргуулах.

3.8 Нийслэлийн бүс нутгийн хөгжлийн үзэл баримтлал, нийслэлийн газар зохион байгуулалтын болон хотын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг олон нийтэд сурталчлах, уулзалт семинар зохион байгуулах

3.9 Газар нь хотын инженерийн хангамжийн нэгдсэн бодлогын хэрэгжилтийг техникийн удирдлагаар хангаж, техникийн урьдчилсан нөхцөл олгох, хяналт тавих, барилга байгууламжийн байршил тогтоох санал боловсруулах үйл ажиллагааг эрхлэнэ.

3.10 Нийслэлийн нутаг дэвсгэрт өмчийн хэлбэр харгалзахгүйгээр үл хөдлөх хөрөнгийг газар эзэмших, ашиглах эрхийн асуудлыг шийдвэрлэсний дараа холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгүүлүүлэх үйл ажиллагааг хариуцах

3.11 Хууль тогтоомж, хотын ерөнхий төлөвлөгөө, газар олголт, ашиглалтын дүрэм, журам зөрчиж гаргасан албан тушаалтны шийдвэрийн талаар дүгнэлт гаргах

3.12 Нийслэлийн Засаг даргаас шилжүүлсэн болон хууль тогтоомжоор олгогдсон бусад эрхийг эдлэх



Нийслэлийн засаг даргын 2002 оны захирамжийн 2 дугаар хавсралт

НЭГ. НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ, ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН БҮТЭЦ, ОРОН ТОО

- Дарга
- Орлогч дарга
- Хуулийн зөвлөх, боловсон хүчин –1
- Мэргэжлийн комиссийн нарийн бичгийн дарга –1
- Тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн бөгөөд архивын эрхлэгч -1

Нийт-5

Хот байгуулалтын хэлтэс:

- Хэлтсийн дарга
- Дүүрэг хариуцсан архитектор – 6
- Инженер – 5
- Захиалагч архитектор, нярав -1

Нийт-13

Газрын харилцааны хэлтэс:

- Хэлтсийн дарга
- Дүүрэг хариуцсан газар зохион байгуулагч - 6
- Ашигт малтмал хариуцсан мэргэжилтэн – 1
- Ногоон бүс хариуцсан газар зохион байгуулагч-1

Нийт-9

Хот байгуулалт, газрын мэдээллийн төв

- Төвийн дарга
- Мэдээллийн сангийн мэргэжилтэн – 4
- Технологийн мэргэжилтэн -3
- Картограф – 1
- Геодезийн инженер – 2

Нийт-11

Орлого санхүүжилтийн хэлтэс:

- Хэлтсийн дарга
- Эдийн засагч, нягтлан бодогч –1
- Дүүрэг хариуцсан төлбөрийн байцаагч -6

Нийт –8

Бүгд –46

**ХОЁР. ДҮҮРГҮҮД ДЭХ ХОТ БАЙГУУЛАЛТ, ГАЗРЫН
ХАРИЛЦААНЫ АЛБАНЫ ОРОН ТОО**

- 1. Баянгол, Баянзүрх, Хан-Уул, Чингэлтэй, Сүхбаатар,
Сонгинохайрхан дүүрэг дэх хот байгуулалт, газрын
харилцааны албаны орон тоо**

Дарга
Архитектор –1
Газар зохион байгуулагч -1
Төлбөрийн байцаагч -3

- 2. Багануур, Налайх дүүрэг дэх хот байгуулалт,
газрын харилцааны албаны орон тоо**

Архитектор -1
Газар зохион байгуулагч-1
Төлбөрийн байцаагч -1

- 3. Багахангай дүүргийн хот байгуулалт, газрын
харилцааны албаны орон тоо**

Архитектор/газар зохион байгуулагч
Төлбөрийн байцаагч

Нийт –44

Бүгд-90